



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/399

Булган сум

**“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025” нэгдсэн
арга хэмжээг зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3, 28.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны хуралдааны VII/38 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025” нэгдсэн арга хэмжээг Булган аймагт зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг “Амар тайван Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025” нэгдсэн арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар ханган үр дүнтэй, хүртээмжтэй хэлбэрээр чанартай гүйцэтгэж, ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

